



**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ,
АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Энэхүү гэрээг нэг талаас Завхан аймгийн Засаг дарга, Завхан аймгийн Завханмандал сумын Засаг дарга ("Засаг дарга" гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Шувуун хар уул ХХК (цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх зүйлийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Завхан аймгийн Улиастай суманд байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Завхан аймгийн Завханмандал сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол мэдээлэл өгч, саналыг нь авах;

2.3. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, төсөл, арга

2.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөн тусгах;

2.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хуулийн хугацаанд зохих журмын дагуу шуурхай шийдвэрлэх, хуулийн хугацаанд хариуг хүргүүлэх;

2.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхай дээр цагдаа болон эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай нөхцөлд дэмжин, хамтран ажиллах;

2.7.Орон нутгийн иргэдэд үнэн зөв, зохистой мэдээлэл өгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчийг үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах, иргэд, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд хуулийн хүрээнд хамтран ажиллах, гарсан зөрчлийг таслан зогсоох;

2.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр, бараа ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

2.9. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллаж мод тарих байршлыг тогтоож өгөх;

2.10. Гэрээний хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5-д заасны дагуу энэхүү гэрээнд тусгагдаагүй аливаа хандив, тусламж, шаардахгүй байх.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1.Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад асуудлаа тавьж шийдвэрлүүлэх;

3.2.Өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухай орон нутгийн иргэдийн хамруулах ажлыг зохион байгуулах;

3.3.Нийт ажлын байрны 20-оос доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах;

3.4.Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэх;

3.5.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

3.6.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлж ажиллах;

3.7.Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;

3.8.Улиастай сумын Жинст багт (Шинээр баригдаж байгаа Хөгжимт жүжгийн театрын урд хэсэгт Богдын голын сав дагуу) 14.5 га талбайд "Соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэн" байгуулах;

3.9.Жил бүр 30-аас доошгүй оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох

3.10."Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд, нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилтийн явцад жилд 10 мянгаас доошгүй мод тарих ажлыг орон нутагтай хамтран хэрэгжүүлэх;

3.11.Завханмандал суманд 4 жилийн хугацаанд гэрээний хавсралтад тусгасан бүтээн байгуулалтын ажлуудыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх;

3.12.Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийг орон нутгийн харьяаллын улсын бүртгэлд бүртгүүлэх;

3.13.Татвар, төлбөр хураамжийг хууль тогтоомжийн дагуу орон нутагт бүрэн төвлөрүүлэх;

3.14.Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг арга зүйг орон нутагт нутагшуулахад хамтран ажиллах;

3.15.Үндсэн болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг орон нутгийн харьяаллын улсын бүртгэлд бүртгүүлэх;

3.16.Ашигт малтмалын ордын нөөц одоо байгаа нөөцийн хэмжээгээр нэмэгдсэн тохиолдолд талуудын тэнцвэртэй үр ашгийг нэмэгдүүлж гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Дөрөв. Хамтын ажиллагааны хороо

4.1.Талуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г байгуулж ажиллуулна.

4.2.Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна.

4.3.Хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.4.Хороо нь гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Тав. Гэрээний хэрэгжилт

5.1.Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5

хоногийн дотор аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Гэрээний хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөг талууд жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хэлэлцэж, батлан хэрэгжүүлнэ.

5.3. Талууд гэрээний биелэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Гэрээний хариуцлага

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран гэрээний хавсралтад заагдсан ажлыг төлөвлөгөөт хугацаанд гүйцэтгэнэ. Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн эрсдэлийн үед төлөвлөгөөт хугацаанд нь гүйцэтгэх боломжгүй бол энэ талаарх баримтыг нөгөө талдаа хүргүүлэх ба энэ тохиолдолд зөрчил гаргасан гэж үзэхгүй.

6.4. Төрийн эрх бүхий байгууллага болон гуравдагч этгээдийн шийдвэр, үйл ажиллагааны улмаас тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа бүрэн болон хэсэгчлэн зогсолт үүссэн, үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон тохиолдолд энэ хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигч төлөвлөгөөнд заасан ажлыг гүйцэтгэхгүй байх эрхтэй.

6.5 Засаг дарга, сум орон нутгийн төрийн байгууллага, албан тушаалтны буруутай, хууль бус шийдвэр үйл ажиллагааны улмаас, эсвэл иргэдийн бослого тэмцэл хурцдаж үймээн үүсэж тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаа богино болон удаан хугацаагаар сул зогсоход хүрэх, Засаг дарга дэмжин ажиллах энэхүү гэрээний үүргээ биелүүлээгүй бол тусгай зөвшөөрөл тухайн хугацаанд хамаарах гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.

Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 4 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа талууд бичгээр мэдэгдэнэ.

8.5. Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЗАВХАНМАНДАТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц.ЛХАГВАСҮРЭН

Хаяг: Завхан аймаг, Улиастай сум,
Нутгийн удирдлагын ордон
Цахим хаяг: za@zavkhan.gov.mn
Утас: 75751155

АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

ШУВУУН ХАР УУЛ ХХК-ИЙН УУРХАЙН
ДАРГА

Э.ГАНБАТ

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
1-р хороо, Алтай-Энгельс 29-120
Цахим хаяг:
Shuvuun_khar_uul@yahoo.com
Утас: 70003785